

# Сэнкакү арлуудын талаар Япон улсын баримтлах байр суурь

/шинэчилсэн/

Япон улсын Гадаад хэргийн яам

## 1. Сэнкакү арлууд нь Япон улсын газар нутгийн салшгүй хэсэг мөн

### 【Япон улсын үндсэн байр суурь】

- “Хуульд захирагдах нь” дэлхий нийтийн энх тайван, тогтвортой байдал болоод хөгжил цэцэглэлийн үндэс юм. Аль ч улс орон энх тайвныг хамгаалах, өөрийн ард түмний аюулгүй байдлыг хангах, тусгаар тогтнол, хуурай газрын болон усан хилээ хамгаалах үүрэг хариуцлагыг үүрдэг бөгөөд Япон улс нь олон улсын хууль эрхзүйн дагуу энэ үүргээ биелүүлэх болно.
- Сэнкакү арлууд нь түүхийн хөдлөшгүй баримт болоод олон улсын хуулийн үүднээс үзвэл Япон улсын газар нутгийн салшгүй хэсэг мөн. Ямар ч маргаагүйгээр, Сэнкакү арлууд нь Япон улсын Засгийн газрын хүчин төгөлдөр хяналтан дор байдаг билээ. (Арлуудын байрлалыг Хавсралт 1-ээс үзнэ үү)
- 1885 оноос эхлэн Японы Засгийн газар нь Окинава мужийн захиргаагаар дамжуулан, мөн бусад арга хэлбэрээр Сэнкакү арлуудын талаар нарийвчилсан судалгаануудыг явуулж ирсэн билээ. Эдгээр судалгаануудын үр дүнд Сэнкакү арлууд дээр хүн амьдарч байгаагүй нь тогтоогдсон бөгөөд Хятадын мэдэлд байсан ямар нэгэн ул мөр олдоогүй байна. Энэхүү нотолгоонд үндэслэн 1895 оны 1 дүгээр сарын 14-ны өдөр Японы Засгийн газар нь арлууд дээр хилийн шон босгож Сэнкакү арлуудыг Японы нутаг дэвсгэрт албан ёсоор нэгтгэх тухай шийдвэр гаргажээ (Хавсралт 2-ыг үзнэ үү). Эдгээр арга хэмжээнүүдийг олон улсын хуулийн хүрээнд газар нутагт эзэмшилээ тогтоох (эзэнгүй газар нутаг буюу terra nullius-т эзэмшилээ тогтоох) зарчмын дагуу явагдсан билээ.
- Сэнкакү арлын орчим загас барих зэрэг үйл ажиллагаа явуулдаг байсан Окинава мужийн нэгэн оршин суугч эдгээр арлуудыг түрээсээр ашиглах хүсэлтээ гаргасны үндсэн дээр тухайн үеийн Засгийн газар 1896 онд уг хүсэлтийг нь ёсоор болгожээ. Ийнхүү зөвшөөрлөө авсны дараа тэрээр ажилчдаа арлуудруу илгээн шувууны өд цуглуулах, хатаасан хар амар загас бэлтгэх, шүр цуглуулах, мал үржүүлэх, лаазалсан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон түлшний зориулалтаар шувууны сангас цуглуулах зэрэг бизнесийн үйл ажиллагаа явуулж байв. Тухайн үеийн Засгийн газраас хувь хүнд Сэнкакү арлуудыг ашиглах зөвшөөрөл олгож, тэрээр уг зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа нээлттэйгээр явуулах боломжтой байсан нь эдгээр арлууд нь Япон улсын хүчин төгөлдөр хяналтанд байсныг илтгэж байгаа болно.
- Эргэн нэгтгэсэн цагаас хойш Сэнкакү арлууд нь Япон улсын нутаг дэвсгэрт багтах Нансэй арлуудын салшгүй хэсэг мөн бөгөөд Япон улсын хүчин төгөлдөр хяналтан дор байсаар ирсэн билээ. Эдгээр арлууд нь 1895 оны 5 дугаар сард хүчин төгөлдөр болсон Шимоносекийн гэрээний 2 дахь заалтын дагуу Чин гүрний зүгээс Японд шилжүүлсэн “Тайвань арал болон Пескадорын арлууд”-ын бүрэлдэхүүнд орж байгаагүй болно. Түүгээр үл барам, 1895 оны 4

дүгээр сард гарын үсэг зурагдаж, 5 дугаар сард хүчин төгөлдөр болсон Шимоносекийн гэрээнээс өмнө буюу 1895 оны 1 дүгээр сард Сэнкакү арлуудыг Япон улсын газар нутгийн бүрэлдэхүүнд нэгтгэх Засгийн газрын шийдвэр гарсан байдаг. Иймд "Япон улс нь Сэнкакү арлуудыг Япон-Чин гүрны дайны дүнд булаан авсан" хэмээх шүүмжлэл нь хууль, эрхзүйн ямар нэгэн үндэслэлгүй болно.

- Сэнкакү арлууд нь Сан-Францискогийн Энхийн гэрээний 2 дахь заалтын дагуу Японы хураалгасан нутаг дэвсгэрт багтаагүй билээ. Уг гэрээний 3 дахь заалтын дагуу Сэнкакү арлуудыг Нансэй арлуудын хэсэг хэмээн үзэж АНУ-ын мэдэлд шилжүүлсэн ба, улмаар 1971 оны 6 дугаар сарын 17-ны өдөр үзэглэсэн Рюүкюү болон Дайтоо арлуудын талаархи Япон, АНУ-ын хооронд байгуулсан гэрээний дагуу Японы захирах эрхийг сэргээсэн бүс нутагт багтсан байна. Япон улс, Сэнкакү арлуудтай холбоотойгоор шийдвэрлэвэл зохих ямар нэгэн "газрын маргаан" үгүй гэсэн байр суурийг баримталж байна.

### **【Хятад улсын зүгээс өөрийн тайлбарыг хийж буй нь ор үндэсгүй юм】**

- 1971 онд НҮБ-ын Ази, Алс дорнодын эдийн засгийн комисс (ECAFE)-оос явуулсан судалгаа нь Дорнод Хятадын тэнгист газрын тосны нөөц байж болзошгүйн шинж тэмдэг илрүүлснээс хойш БНХАУ болон Тайваны тал Сэнкакү арлуудын эзэмшлийн талаархи тус тусын асуудлыг анх албан ёсоор тавьж эхэлжээ. Үүнэс өмнө аль нэгэн улс орон, бүс нутгийн зүгээс Япон улсын эзэмшлийг Сэнкакү аралд тогтоосон талаар эсэргүүцэл илэрхийлж байгаагүй болно.

- 1920 оны 5 дугаар сард Нагасаки дахь Хятадын консулаас Сэнкакү арлын орчим Фүжиан мужийн хятад загасчид осолдсонтой холбогдуулан ирүүлсэн талархлын захидалд "Японы эзэнт гүрний Окинава мужийн Яэяама дүүргийн Сэнкакү арлууд" хэмээн бичсэн байдаг (Хавсралт 2-ыг үзнэ үү). Түүнчлэн, 1953 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн БНХАУ-ын "Ардын Сонин"-д хэвлэгдсэн "Рюүкюү арлуудын иргэд АНУ-ын эзэрхийллийн эсрэг тэмцэж буй нь" нэртэй өгүүллэгт Рюүкюү арлууд нь "Сэнкакү арлуудыг багтаасан нийт 7 бүлэг арлаас бүрддэг" хэмээн тодорхой бичсэн байдаг (Хавсралт 3-ыг үзнэ үү). Үүнээс гадна, 1933 онд Хятад улсад хэвлэгдсэн "Бүгд найрамдах Хятад улсын шинэ газрын зураг" (Хавсралт 4-ийг үзнэ үү), мөн 1960 онд БНХАУ-д хэвлэгдсэн "Дэлхийн атлас" (Хавсралт 5-ыг үзнэ үү) зэрэгт Сэнкакү арлуудыг Япон улсын бүрэлдэхүүнд багтаан харуулсан байдаг.

- Сүүлийн өдрүүдэд БНХАУ-ын зүгээс "Сэнкакү арлуудыг Каир болон Потсдамын Тунхаг бичгийн дагуу Хятад улсад буцаан өгсөн бөгөөд Япон улс Дэлхийн II дайны үр дүнг эсэргүүцэж байна" гэх мэтээр тайлбарлаж байгаа боловч, Сэнкакү арлуудыг Япон улс эзэмших болсон нь Дэлхийн II дайнтай ямар нэгэн холбоогүй билээ. Сан-Францискогийн энхийн гэрээгээр Дэлхийн II дайны дараах Япон улсын нутаг дэвсгэрийг хуулийн дагуу тодорхойлсон бөгөөд холбогдох бусад гэрээ хэлэлцээрүүдэд ч Сэнкакү арлуудыг Япон улсын эзэмшилд хэдийнээ байсан нутаг дэвсгэр хэмээн үзсэн байдаг.

- Тодруулбал, Сан-Францискогийн Энхийн гэрээний 2 (b) заалтын дагуу Япон улс нь Япон-Чин гүрны дайны дүнд Чин гүрний зүгээс шилжүүлсэн "Тайвань арал болон Пескадорын арлууд"-ыг эзэмшихээс татгалзсан нь үнэн

боловч, /1/ АНУ нь Сан-Францискогийн Энхийн гэрээний 3 дахь заалтын дагуу Сэнкакү арлуудыг Нансэй арлуудын хэсэг хэмээн үзэж өөрийн захиргаанд оруулж байсан, /2/ 1972 онд Рюүкюү болон Дайтоо арлуудын талаархи Япон, АНУ-ын хооронд байгуулсан гэрээний дагуу “Японы захирах эрхийг сэргээсэн бүс нутаг”-т тодорхой багтаж байсан гэсэн хоёр шалтгаанаар Сэнкакү арлууд “Тайвань арал болон Пескадорын арлууд”-ад багтах ёсгүй нь ойлгомжгүй.

Түүгээр үл барам, Сан-Францискогийн Энхийн гэрээний 3 дахь заалтын дагуу АНУ-ын захиргаанд шилжүүлсэн нутаг дэвсгэрт Сэнкакү арлууд багтаж байсан талаар 1970-аад он хүртэл БНХАУ-ын зүгээс ямар ч эсэргүүцэл мэдүүлж байгаагүй болно.

## **2. Япон улсын Засгийн газар Сэнкакү арлуудыг эзэмшилдээ авсан нь тайван замаар тогтвортойгоор зохицуулан удирдах зорилгыг агуулж байна**

- Энэ удаа Япон улсын Засгийн газрын эзэмшилд шилжин ирээд буй гурван арал (Үоцүри, Китакожима болон Минамикожима)-аас бүрдэх газар нутаг нь 1932 онд хувь хүн худалдан авах хүртэл Япон улсын Засгийн газрын эзэмшилд байжээ. Япон улсын Засгийн газраас эдгээр арлуудыг эзэмшилдээ буцаан авах шийдвэр гаргасны дүнд дотоодын хуулийн дагуу бодит хөрөнгийг шилжүүлэх ердийн үйл ажиллагаа явагдсан бөгөөд энэ нь өнөөгийн нөхцөл байдлыг үндсээр нь өөрчилсөн хэрэг огт биш юм. Үүнээс гадна, Засгийн газар нь Сэнкакү арлуудын бүрэлдэхүүнд орох Тайшоо арлыг өмчлөх эрхээ тууштай хадгалсаар иржээ.

- Япон улсын Засгийн газрын энэхүү шийдвэрийн зорилго нь арлуудыг урт хугацаанд тайван замаар тогтвортойгоор зохицуулан удирдах явдлыг бататгахын хамт Сэнкакү арлуудын хооронд болоод эргэн тойронд нь далайн тээврийн аюулгүй үйл ажиллагааг хангахад оршиж байгаа болно. Энэ нь Япон улсын нутаг дэвсгэрийн дотор, Япон улсын дотоодын хуулийн хүрээнд явагдсан газар өмчлөх эрхийг хувь эзэмшигчээс Япон улсын Засгийн газарт шилжүүлсэн хууль ёсны ердийн шилжүүлэх үйл ажиллагаа бөгөөд бусад улс орон, бүс нутагтай аливаа асуудал үүсгэх учиргүй билээ.

- Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын зүгээс усан хилийг идэвхийлэн зөрчих болж, Сэнкакү арлууд орчим өдөөн хатгалгын шинж бүхий үйлдлүүдийг гаргах боллоо. Улсын эзэмшлийн хөлөг онгоц болоод идэвхтэн тэмцэгчдийн завь Япон улсын усан хилийг нэг бус удаа зөрчсөн нь Япон улсын хувьд сэтгэл улам ихээр зовоосон явдал болоод байна. Ийм нөхцөлд Токио хотын захиргааны зүгээс Сэнкакү арлуудыг худалдан авах төлөвлөгөөг гаргасан билээ. Япон улсын Засгийн газар нь БНХАУ-ын талаас гаргаж буй мэдэгдлийг хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй хэдий ч, зарим үйлдлүүд нь хэрэг дээрээ Япон-Хятадын харилцаанд ноцтой аюул учруулж болзошгүй хэмээн зовниж байна. Энэ утгаараа, энэ удаагийн өмчлөх эрхийг шилжүүлэх үйл ажиллагаа нь арлуудыг тайван замаар, тогтвортойгоор урт хугацаагаар зохицуулан удирдах явдлыг бататгах хамгийн оновчтой бөгөөд сайн арга байсан юм.

- Япон улсын хувьд Япон-Хятадын харилцаа нь хамгийн чухал хоёр талт харилцаануудын нэг билээ. Ази, Номхон далайн бүсийн тогтвортой байдал,

хөгжил цэцэглэлд Хятад улсын гүйцэтгэж буй үүрэг нэн чухал. Дээрхи асуудал нь Япон-Хятадын харилцаанд сөрөгөөр нөлөөхийг Япон улс хүсэхгүй байгаа болно. Япон улс нь Хятад улстай стратегийн нэгдсэн ашиг сонирхолд тулгуурласан харилцан ашигтай харилцаагаа улам бүр гүнзгийрүүлэн, бүс нутгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн хамтын ажиллагаагаа бэхжүүлэхийг зорьж байна. Дорнод Хятадын тэнгисийг “энх тайван, хамтын ажиллагаа, нөхөрлөлийн тэнгис” болгохын тулд хоёр орны хооронд тохиролцсон “Зургаан санаачлага”-ын хүрээний “Далай, тэнгисийн асуудлаархи Япон-Хятадын өндөр хэмжээний зөвлөлгөөн”-өөр дамжуулан хоёр орны далай, тэнгисийн асуудал хариуцсан байгууллага хоорондын харилцан ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэх замаар хамтын ажиллагаагаа бэхжүүлнэ.

### **3. Ямар ч шалтгаантай байсан, хүчирхийллийн үйлдлийг зөвтгөхгүй**

- БНХАУ-ын хэд хэдэн бүс нутагт Японы эсрэг жагсаал цуглаан явагдаж, Японы дипломат төлөөлөгчийн газруудын зүг чулуу болон бусад аюултай эд зүйлс шидэх, япон иргэдийн эсрэг хэрцгий үйлдэл гаргах, Японы харьяа компаниудын эд хөрөнгийг галдан шатаах, сүйтгэх, тонон дээрэмдэх явдал гарсан нь нэн харамсалтай.
- Ямар ч шалтгаантай байсан хүчирхийллийн үйлдлийг зөвтгөх үчиргүй бөгөөд үзэл бодлын зөрүүг тайван замаар илэрхийлэх нь зүйд нийцнэ. Энэ бол олон улсын хамтын нийгэмлэгийн нийтлэг ашиг сонирхол юм.

(Сэнкакү арлуудын талаархи Япон улсын байр суурийн тухай нэмэлт мэдээллийг <http://www.mofa.go.jp/region/asia-paci/senkaku/senkaku.html> хаягаар орж үзнэ үү)

Хавсралтын тайлбар

#### Хавсралт 1

/Сэнкакү арлуудын байршил/

#### Хавсралт 2

Сэнкакү арлуудыг Япон улсын газар нутгийн бүрэлдэхүүнд нэгтгэх Засгийн газрын 1895 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн шийдвэр

### Хавсралт 3

Нагасаки дахь Хятадын консулаас ирүүлсэн талархлын захидал

Бүгд найрамдах Хятад улсын 8 дахь оны (1919) өвөл Фүжиан мужийн Хуйан дүүргийн 31 загасчин шуурганд төөрч Японы эзэнт гүрний Окинава мужийн Яэяама дүүргийн Сэнкакү арлуудын Уайо арлын эрэгт осолдон газардсан билээ. Японы эзэнт гүрний Яэяама дүүргийн Ишигаки тосгоны иргэд аврах ажиллагааг эрчимтэй явуулсны үр дүнд тэд эх нутагтаа эсэн мэнд эргэн ирж чадлаа. Сайхан сэтгэл гарган аврах ажиллагааг хичээл зүтгэл гарган гүйцэтгэсэн тосгоны иргэдэд гүн хүндэтгэлээ илэрхийлэхийн хамт уг захидлаар дамжуулан талархал илэрхийлье.

Нагасаки хотод суугаа Бүгд найрамдах Хятад улсын консул

Бүгд найрамдах Хятад улсын 9 дахь оны (1920) 5 дугаар сарын 20-ны өдөр

### Хавсралт 4

“Ардын сонин”-ы 1953 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн дугаарт хэвлэгдсэн “Рюүкюү арлуудын иргэд АНУ-ын эзэрхийллийн эсрэг тэмцэж буй нь” нэртэй өгүүллэгийн хэсгээс

Рюүкакү арлууд нь БНХАУ-ын Тайваны Зүүн-хойд хэсэг болон Японы Кюүшүүгийн баруун өмнөд хэсгийн хооронд орших тэнгист таран байрладаг. Тэдгээр нь 7 хэсэг арлуудаас бүрдэх бөгөөд үүнд Сэнкакү арлууд, Сакишима арлууд, Дайтоо арлууд, Окинава арлууд, Оошима арлууд, Токара арлууд болон Оосүми арлууд багтана. Тэд тус бүртээ олон тооны том, жижиг арлуудаас бүрдэх бөгөөд нийт нэр бүхий 50, нэргүй 400 орчим арал байдаг байна. Тэдгээр нь нийт 4,670 хавтгай дөрвөлжин километр талбайг эзэлдэг. Хамгийн том нь Окинава арал бөгөөд тэрээр 1211 хавтгай дөрвөлжин километр талбайг эзэлнэ. Хоёрдахь том арал бол Оошима арлуудад багтах Амами арал ба тэрээр 730 хавтгай дөрвөлжин километр талбайг эзэлнэ. Рюүкюү арлууд нь 1000 гаруй километрт сунах бөгөөд арлуудын дотор талд Зүүн Хятадын тэнгис, гадна талд нь Номхон далай оршино.

### Хавсралт 5

1933 онд Хятадад хэвлэгдсэн “Бүгд найрамдах Хятад улсын шинэ газрын зураг”-т Сэнкакү арлуудыг Японы бүрэлдэхүүн хэсэг хэмээн харуулсан байгаа нь

### Хавсралт 6

1958 онд БНХАУ-д хэвлэгдсэн “Дэлхийн атлас”-т Сэнкакү арлуудыг Японы бүрэлдэхүүн хэсэг хэмээн харуулсан байгаа нь (Хоёрдугаар хэвлэлт нь 1960 онд гарсан).